

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Оршил.....	3
Бүлэг 1. Төслийн товч танилцуулга.....	4
1.1 Тайлангийн нэр.....	4
1.2 Төслийн зорилго.....	4
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	4
1.4 Төслийн байршил.....	4
1.5 Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
1.6 Төслийн геологийн нөөц.....	5
1.7 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, үйлдвэрлэлийн нөөц.....	6
1.8 Төслийн хүчин чадал.....	6
1.9 Ил уурхайн ашиглалтын технологи.....	6
1.10 Нийгэм, эдийн засгийн үр өгөөж.....	6
1.11 Орлого, хөрөнгө оруулалт, зарлага.....	6
Бүлэг 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл.....	7
2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	7
2.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	9
2.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	9
2.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	10
2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	10
2.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	10
2.7 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	12
2.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	12
2.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	12
2.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	13
2.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	15
Дүгнэлт.....	16
Ашигласан материал.....	17
Хавсралтын жагсаалт.....	17

ХҮСНЭГТИЙН ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэгүүдийн солбилцол.....	4

Хүснэгт 3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийн хүснэгт	7
Хүснэгт 4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл.....	9
Хүснэгт 5.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	10
Хүснэгт 6.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	12
Хүснэгт 7.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл.....	12
Хүснэгт 8.	ОХШХ-ийн гүйцэтгэл	13
Хүснэгт 9.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл.....	13
Хүснэгт 10.	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөөний гүйцэтгэл	15
Хүснэгт 11.	БОМТ-ний хэрэгжилтийн нийт зардал.....	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг	5
Зураг 2.	Тээвэрлэлтийн зам арчилгаа, усалгааны зураг	8
Зураг 3.	Уурхайн замын тэмдэгжүүлэлтийн зураг	9
Зураг 4.	Гал унтраах хэрэгслийн зураг	11
Зураг 5.	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалтын үеийн зураг	11
Зураг 6.	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалтын үеийн зураг	12
Зураг 7.	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан зураг	14
Зураг 8.	Ажилчдыг ХАБ-ын сургалтад хамруулсан үеийн зураг	14

ОРШИЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан /гол болон сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт/, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт зэргээс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

БОМТБТ –гийн зорилго: “Цээцээ импекс” ХХК –ийн барилгын чулууны уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд тайлагнахад оршино.

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төслийн үйл ажиллагааны бүхий л үе шат бүрт байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Цээцээ Импекс” ХХК-ний авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дагуу боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29–ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын БОМТ-нд 2023 онд нийт 7.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Тайлангийн нэр

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

1.2 Төслийн зорилго

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын барилгын чулууг олборлож, бутлан ангилан, сайн чанарын дайрга зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Цээцээ Импекс” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011137041
3	Уурхайн нэр		Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд
4	Ордын нэр		“Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”
5	Ордын байршил	Аймаг/ Хот	Улаанбаатар
6		Сум/Дүүрэг/	Хан-Уул
7	Ашигт малтмалын төрөл		Барилгын чулуу
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		19/М017
9	Ашиглалт эхэлсэн огноо		2019
10	Компанийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
11		Сум/Дүүрэг	Чингэлтэй
12		Баг/Хороо	19-р хороо
13		Гудамж/Байр	Шадивлан 1-90 404 тоот
14		Шуудангийн хайрцаг	
15		Утас	976-11-461757
16		Факс	976-11-461757
17		Гар утас	94005431
18		Цахим шуудан	
19	Цахим хуудас		
20	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Э.Гантуяа
21		Гар утас	91915431
22		Факс	
23		Цахим шуудан	Tsetsee_impex@yahoo.com


1.4 Төслийн байршил

“Сондуулт” талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 12-р хорооны нутагт Морин уулын өмнөд хэсэгт оршино.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	106	43	41.03	47	48	40
2	106	43	39.7	47	48	50.87
3	106	43	49.59	47	48	58
4	106	44	11.02	47	48	58
5	106	44	11.3	47	48	40
6	106	42	50	47	48	40
7	106	43	36.25	47	48	40
8	106	43	32.78	47	48	49.15
9	106	43	30.35	47	48	51.35
10	106	43	22.44	47	48	52.19

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
11	106	43	15.21	47	48	50.57
12	106	43	13.7	47	48	42.09
13	106	43	11.15	47	48	42.56
14	106	43	5.89	47	48	47.97
15	106	43	2.95	47	48	48.52
16	106	43	0.95	47	48	42.73
17	106	42	59.27	47	48	42.06
18	106	42	50	47	48	42.06



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

1.5 Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Нийслэлийн засаг даргын тамгын газраас “Цээцээ импекс” ХХК-д 54.07 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож 19/М017 дугаар бүхий гэрчилгээг 2019 оны 02 сарын 12-ны өдөр олгосон байна.

1.6 Төслийн геологийн нөөц

Анх 2017 онд “Цээцээ Импекс” ХХК нь “Сондуулт” талбайн баруун хэсэгт хайгуулын ажил гүйцэтгэн үр дүнгийн тайлан бичсэн бөгөөд “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” гэж нэрлэн 2017 онд нөөцийг В+С зэрэглэлээр 2382.57 мян.м³ буюу 6313.8 мян.тн гэж тооцоолсон ба нөөцийн тооцоо бүхий тайланг ЭБМЗ-ийн хуралд хэлэлцүүлэн 2018 оны 07 сарын 05 өдрийн ХХ-09-12 дугаар дүгнэлт, АМГТГ-ыг даргын 2018 оны 09 сарын 25 өдрийн н/109 дугаар тушаалаар нөөцийг бүртгүүлсэн байдаг.

2019 онд Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол хийсэн бөгөөд уг тооцооны үр дүнгээр нөөцийг нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 19,400.32 мян.м³ буюу 51.41 сая.тн гэж тооцоолж ЭБМЗ-ийн хуралд хэлэлцүүлэн 2019 оны 04 дүгээр сарын 19 өдрийн ХХ-07-05 дугаар дүгнэлт, АМГТГ-ын даргын 2019 оны 06 сарын 18 өдрийн н/59 дугаар тушаалаар нөөцийг дахин бүртгүүлсэн байна.

1.7 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, үйлдвэрлэлийн нөөц

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын уурхайн ашиглалтаар 2 ухаш үүснэ. Талбай-1 дэх ил уурхай ойролцоогоор 800 м урттай, 350 м өргөнтэй байх бөгөөд 18.3 га талбайг хамарсан ухаш үүсэх бол талбай-2 дахь ил уурхай ойролцоогоор 640 м урттай, 390 м өргөнтэй байх бөгөөд 23.8 га талбайг хамарсан ухаш болох юм.

Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан В+С зэргээр 500.0 мян.м³ буюу 1,300.0 мян.тн дайрга болж байна.

1.8 Төслийн хүчин чадал

“Морин уулын өмнөд хэсгийн” барилгын чулууны уурхайгаас 2023 онд 474,7 мян.м³ барилгын чулуу олборлон борлуулна. Уурхай нь 4 сарын 15-аас 10 сарын 15-ны хооронд тасралтгүй ажиллана. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

1.9 Ил уурхайн ашиглалтын технологи

Ил уурхайн талбай: Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын уурхайн ашиглалтаар 2 ухаш үүснэ. Талбай-1 дэх ил уурхай ойролцоогоор 800м урттай, 350м өргөнтэй байх бөгөөд 18.3 га талбайг хамарсан ухаш үүсэх бол талбай-2 дахь ил уурхай ойролцоогоор 640 м урттай, 390 м өргөнтэй байх бөгөөд 23.8 га талбайг хамарсан ухаш болох юм.

Ил уурхайн гүн: Ил уурхайн ёроолын түвшин талбай-1 хувьд +1340м бол талбай-2 хувьд +1360 м байх бөгөөд ил уурхайн хамгийн их гүн нь харгалзан 63м, 70 м байна.

1.10 Нийгэм, эдийн засгийн үр өгөөж

Орд ашиглалтын 30 жилийн хугацаанд нийт 14,021.6 мян.м³ дайрга олборлон борлуулна. 1 м³ дайрганы үнийг -5+0 мм ширхэглэлтэй дайрга 14000 төгрөг, -10+5 мм ширхэглэлтэй дайрга 14000 төгрөг, -20+10 мм ширхэглэлтэй дайргыг 14000 төгрөгөөр борлуулахаар тооцсон.

Орд ашиглалтын хугацаанд нийт 196.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 140.6 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал гарган, 34.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын хугацаанд нийт 45.7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 8 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 1.46 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 19% байна, хөрөнгө оруулалтаа 3.2 жилд нөхнө.

1.11 Орлого, хөрөнгө оруулалт, зарлага

Борлуулалтын орлого. Ордтой ойролцоо орших дайрганы уурхайн бүтээгдэхүүний дундаж үнийг үндэслэн 1 м³ 0-5 мм ширхэглэлтэй дайргыг 14,000 төгрөг, 5-10 мм ширхэглэлтэй дайргыг 14,000 төгрөг, 10-20 мм ширхэглэлтэй дайргыг 14,000 төгрөгөөр борлуулахаар эдийн засгийн тооцоог хийлээ. Орд ашиглалтын 30 жилийн хугацаанд нийт 14,021.6 мян.м³ дайрга борлуулж 196.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллана.

Хөрөнгө оруулалт. Ордын уул техникийн нөхцөл, техник тоног төхөөрөмж, үйлдвэрийн хүчин чадал, үйлдвэрлэлийн нөөц зэрэгт үндэслэн шаардлагатай бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн хэрэгцээг тооцон үндсэн хөрөнгийн тоцооллыг хийж гүйцэтгэсэн. Төслийн анхны хөрөнгө оруулалт 4.0 тэрбум төгрөг бөгөөд ашиглалтын хугацаанд нийт 11.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ.

Үйл ажиллагааны зардал. Морин уулын өмнөд хэсгийн уурхайн үйл ажиллагааны зардлыг төслийн үндсэн хэсэг нэгж болох төв оффис, уулын хэсэг, засвар механик, аж ахуй, үйлчилгээний хэсэг тус бүрээр тооцсон.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийн хүснэгт

№	Хэрэгжүүлсэн ажил	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
Агаарын чанар			
1	Тоос үүсгэх талбайг тогтмол услах	Үйл ажиллагааны зардлаар	Тээвэрлэлтийн зам, уурхай, кемп орчмыг тоосжилтоос сэргийлж тогтмол усаар шүршиж, усалж байсан.
2	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	10796.9	Хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулж, засвар үйлчилгээг тогтмол хийлгэсэн.
Гадаргын ба газрын доорх усны нөөц			
1	Усны хэмнэлттэй ашиглах, усыг дахин ашиглах	107.6	Ус ашиглах гэрээ байгуулсан тус компанийн зүгээс ус ашиглах төлбөрийг тогтмол төлж байсан. Усны төлбөрийг төлсөн баримтыг хавсаргав.
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч			
1	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах.	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайн замыг тэмдэгжүүлсэн зургийг оруулав.
2	Засвар үйлчилгээ хийхэд хөрсийг Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх нөхцөл бүрдүүлэх бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж шинэ хөрсөөр сэлбэх	Үйл ажиллагааны зардлаар	Техник хэрэгслүүдийн засвар үйлчилгээ хийхэд хөрсийг Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байхад онцгой анхаарч ашигласан бөгөөд бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж шинэ хөрсөөр сэлбэж ажилласан.
3	Уулын ажлыг зөвхөн уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Үйл ажиллагааны зардлаар	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажлыг хийж гүйцэтгэсэн.
Ургамлан нөмрөг			
1	Тоос үүсэх талбайг услах	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайн зам талбайг усласан үеийн зургийг оруулав.
Нийт		10904.5	

Хүнд машин механизмуудыг техникийн үзэгт оруулж, засвар үйлчилгээг хийлгэж байсан, усны төлбөр төлсөн санхүүгийн баримтыг хавсралтаар оруулав.



Зураг 2.Тээвэрлэлтийн зам арчилгаа, усалгааны зураг



Зураг 3. Уурхайн замын тэмдэгжүүлэлтийн зураг

2.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах төслийн явцад нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн хаалтын дараа хийнэ. Нөхөн сэргээлтийн хаалтын ажилд тусгай зардал төлөвлөн ажиллах бөгөөд ордын ашиглагдсан орон зайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

2.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажил хийнэ.	5,955.0	Төлөвлөгөөт өртөгийн зардлыг хандивласан санхүүгийн баримтыг хавсралтад хавсаргав.
	Нийт		5,955.0	

“Цээцээ Импекс” ХХК нь Нийслэлийн Байгаль орчны газраас санал болгосны дагуу Сонгинохайрхан дүүргийн “Инчон мөрөөдлийн төгөлд” мод тарих ажилд 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланд тусгагдсан Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөт өртөгийн зардлыг хандивласан болно.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Ойн мэргэжлийн байгууллага болох НҮРИ ХХК болон Нийслэлийн байгаль орчны газартай хамтран Сонгинохайрхан дүүргийн “Инчон мөрөөдлийн төгөлд” 5 га талбайд 6000 ширхэг шинэс мод тарих үйл ажиллагааг зохион байгуулсан. Уг ажилд НБОГ, Нүри ХХК-ийн захирал Х.Лхагважав, ойн инженер

А.Номин, техникч Б.Мөнхбаатар, Э.Гансүх нар болон орон нутгийн улирлын түр ажилчид, нийт 12 хүн хамтран ажилласан байна.

Ойн зурвасын ажлыг 2023 оны 10-р сарын 05-с 06-р сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд 3 настай 6000 ширхэг бортоготой шинэсийг тарилтад бэлтгэж нэмэлтээр усны машин түрээслэж 7 хоногт 32 тонн усаар усалж байв.

Санхүүжилтийн хүрээнд нийт 80 сая төгрөгийн төсөв бүрдүүлсэн бөгөөд үүнд “Цээцээ импекс” ХХК нь 5.9 сая төгрөгийн төсөвт өртөгийг хандив өгч ажиллаа. Санхүүгийн баримтыг хавсралтад хавсаргав.

2.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд ашиглах уурхайн эдэлбэр газрын ойр орчимд түүх, дурсгалын зүйлс болон археологи, палентлогийн олдвор илрээгүй. Хэрэв уурхайн эдэлбэр газрын хүрээнд түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг хорооны захиргаанд болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулан хамтран ажиллана.

2.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйл ажиллагааны зардлаар	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж хяналт тавьж ажилласан.
2	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Дүүргийн онцгой байдлын хэлтэстэй хамтрах ажилчдад галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан.
3	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	419.0	Ажилчдын байр, ил уурхайн орчим, уурхайн кемпэд гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж, галын ослын үед хэрэгжүүлэх заавал зөвлөмж бүхий самбар, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.
Нийт зардал		419.0	

Галын хэрэгсэл худалдан авсан санхүүгийн баримтуудыг хавсралтад хавсаргав.



Зураг 4.Гал унтраах хэрэгслийн зураг



Зураг 5.Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалтын үеийн зураг



Зураг 6. Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалтын үеийн зураг

2.7 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх	“Пауэр Блест” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу	“Пауэр Блест” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилладаг бөгөөд тус компанийн мэргэжлийн инженерүүд гэрээний дагуу хариуцан гүйцэтгэдэг. Тэсэлгээний ажлын аюулгүй байдлыг гэрээт компани тусгай төлөвлөгөөний дагуу хариуцан ажилладаг. Үүргийн дагуу тэсрэх бодистой аюулгүй ажиллах дүрмийг баримтлан ажилладаг.
2	Тэсрэх бодисыг хадгалах, ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх		
3	Тэсрэх бодис асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг бэлтгэж бэлэн болгох		
4	Ашиглагдсан тэсрэх бодисын сав баглаа боодлыг орон нутгаас зааж өгсөн талбайд булшлах, устгах арга хэмжээ авах		

“Пауэр Блест” ХХК-тай байгуулсан гэрээний хуулбарыг хавсралтад хавсаргав.

2.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Цээцээ Импекс” ХХК нь Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тэй хог хаягдлын гэрээ байгуулан ажилладаг бөгөөд гэрээт байгууллага хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, компаний зүгээс хяналт тавьж ажилладаг.

Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх	1285.4	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний хуулбарыг хавсралтад хавсаргав.
	Нийт зардал	1285.4	

2.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

БОХШХ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно.

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлсны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

Хүснэгт 8. ОХШХ-ийн гүйцэтгэл

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
Агаар			
1	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйл ажиллагааны зардлаар	БОХЗТЛабораторит бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхайгаас дээж авч шинжилгээ хийлгүүлсэн.
Хөрс			
1	Хөрсний химийн үзүүлэлт (рН, EC2.5 dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	Үйл ажиллагааны зардлаар	Хөрсний хими, механик бүрэлдэхүүний задлан шинжилгээг ШУА - Газарзүй-Геозкологийн Хүрээлэн – Хөрсний лабораторит шинжлүүлсэн
2	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Үйл ажиллагааны зардлаар	шинжлүүлсэн шинжилгээний хариуг хавсаргав
Ус			
1	Усны химийн шинжилгээ (рН, ЕС, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Үйл ажиллагааны зардлаар	Худгийн усны шинжилгээг ШУА - Газарзүй-Геозкологийн Хүрээлэн – Усны шинжилгээний лабораторит шинжлүүлсэн шинжилгээний хариуг хавсаргав
Нийт зардал		Үйл ажиллагааны зардлаар	

2.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Үйл ажиллагааны зардлаар	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажилладаг.
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан.
3	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Ажилчдыг байгаль орчныг хамгаалах талаар сургалтад хамруулсан.
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр хангах	4255.8	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр бүрэн хангасан. Мөн анхны тусламжын хайрцагт эм бэлдмэл нөхөж хийсэн.
Нийт зардал		4255.8	



Зураг 7. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан зураг



Зураг 8. Ажилчдыг ХАБ-ын сургалтад хамруулсан үеийн зураг

2.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 10. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулсан газар
1	Тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	11-р сард	Нийслэлийн байгаль орчны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	12-р сард	Нийслэлийн байгаль орчны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам

ДҮГНЭЛТ

Хүснэгт 11. БОМТ-ний хэрэгжилтийн нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тухайн жилийн БОМТБ-ийн нийт зардал /мян.төг/, 2023 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10904.5
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5955.0
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	419.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1285.4
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	4255.8
9	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	Үйл ажиллагааны зардлаар
	Нийт	22819.7

“Цээцээ импекс” ХХК –ийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 12–р хорооны нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийн тайланг боловсруулан гаргалаа.

“Цээцээ импекс” ХХК нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг бүрэн авч хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир уурхайн хаалтын дараа нөхөн сэргээлт бүрэн хийгдэнэ.

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын БОМТ-нд 2023 онд нийт 7.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд “Цээцээ импекс” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд 22.8 сая төгрөг байна.

“Цээцээ Импекс” ХХК-ийн Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангасан гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
2. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
3. Монгол улсын засгийн газрын 2023 оны 02 сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нүүр
4. БОХ-3 маягт
5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн дүгнэлт, Нөөц хүлээж авсан тушаал
6. ЭБМЗ-ийн хурлын дүгнэлт
7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд авсан дээжүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн
8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээний санхүүгийн баримт
9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төсөвт өртөгийн зардлыг хандивласан санхүүгийн баримт
10. Хог хаягдлын менежментийн хүрээнд хог хаягдлын компанитай байгуулсан гэрээний хуулбар
11. Хог хаягдлын менежментийн хүрээнд хог хаягдлын гэрээний дагуу тогтмол төлбөр төлж байсан санхүүгийн баримт
12. Осол, эрсдэлийн менежментийн хүрээнд галын хэрэгсэл, анхны тусламжийн эм бэлдмэл худалдан авсан санхүүгийн баримт.
13. Осол, эрсдэлийн менежментийн хүрээнд Дүүргийн онцгой байдлын газартай хамтран “Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний сургалт зохион байгуулсан бүртгэл.
14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авсан санхүүгийн баримт

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл
3. Кадастрын лавлагаа
4. Нөөцийн тушаал, дүгнэлт
5. ТЭЗҮ-ний тушаал, дүгнэлт
6. Ерөнхий үнэлгээний дүгнэлт
7. Уул уурхайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас
8. Ус ашиглах тухай
9. Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримт
10. Нөөцийн дэвсгэр зураг
11. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 2023 оны жилийн мэдээ (БОХ-3 маягт)
12. БОМТ-ний ажилд зарцуулсан зардлын санхүүгийн баримтууд
13. “Тэрбум мод” төслийн хүрээнд хийгдсэн ажил
14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд
15. Осол, эрсдлийн менежментийн хүрээнд
16. Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд
17. ОХШХ-ийн лабораторийн шинжилгээний хариу (Агаар, Хөрс, Ус), төлбөр төлсөн баримт

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2008.02.13

/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011137041

/Улсын бүртгэлийн дугаар/

2804816

/Регистрийн дугаар/

Цэцээ-Импекс

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Шийдвэр

/Шийдвэрийн нэр/

1

/дугаар/

2004.01.28

он, сар, өдөр

511000

/код/

Гадаад худалдаа

/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

хугацаа

2

/шишүүдийн тоо/

1,000.0

/өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Сүхбаатар дүүрэг, 18-р хороо, Бэлхийн гудамж, 54 - 314, утас1:91913170, утас2:, факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



Улсын бүртгэлийн алба

/Бүртгэсэн байгууллагын нэр/

УХА0175

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, тэмдэг
Голомт банк 1-р ТГ	Төгрөгийн	1102017495	Б.Мөнхтөвшин

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэг
1	269300, Тоосгоны үйлдвэрлэл эрхлэх туслах үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2008.04.02	Б.Мөнхтөвшин
1	514300, Тоосгоны худалдаа эрхлэх туслах үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2008.04.02	Б.Мөнхтөвшин
3	Гантөмөр овогтой Долгоржав -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2013.01.16	Г.Өлзийбаяр
4	Дүрмийн шинэчилсэн найруулагыг бүртгэв.	2013.08.14	В.Хандсүрэн
4	Энхжаргал овогтой Чинбат -г Захирал-р томилсныг бүртгэв.	2013.08.16	В.Хандсүрэн
5	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 2 хасагдаж үүссэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2013.08.16	В.Хандсүрэн
6	Улаанбаатар, Чингэлтэй, 19-р хороо, , шөвцөлөн 1, , 90 тоот тоот. Утас1 99118716, Утас2 . Факс хаягийг шинээр бүртгэв.	2013.08.16	В.Хандсүрэн
7	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.1-д заасан шаардлагыг хангасан тул " 2392 Тоосгоны үйлдвэрлэл, 4663 Тоосгоны худалдаа, " эрхлэгчээр бүртгэв.	2014.01.27	Г.Өлзийбаяр
8	0810 Ашигт малтмалын ашиглалт /2007.01 29-нөөс 30 жил/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2014.02.10	П.Энхбаяр
9	9820 Чулуу бутлах үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2014.02.12	Э.Эрдэнэбилэг
10	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.5-д заасан шаардлагыг хангасан тул " 9820 Чулуу бутлах үйлчилгээ, " эрхлэгчээр бүртгэв.	2014.02.12	Э.Эрдэнэбилэг
11	Энхжаргал овогтой Гантуяа -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2014.06.24	У.Даваасүрэн

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүдээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn


2019.03.25 № 068/1744

танай _____-ны № _____-т

ЦЭЭЦЭЭ ИМПЕКС ХХК-Д


Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/M017 тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дугаар тогтоолын Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай тус тус давхцалгүй байна.

Зурган мэдээллийг хавсаргав.

ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ
ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.БАТЗАЯА

1119278525 +9085084

021707



№	лицензийн дугаар	хг	км	кс	үг	үм	үс
1	19/M017	106	43	41,03	47	48	40
2		106	43	39,7	47	48	50,87
3		106	43	49,59	47	48	58
4		106	44	11,02	47	48	58
5		106	44	11,3	47	48	40
1		106	42	50	47	48	40
2		106	43	36,25	47	48	40
3		106	43	32,78	47	48	49,15
4		106	43	30,35	47	48	51,35
5		106	43	22,44	47	48	52,19
6		106	43	15,21	47	48	50,57
7		106	43	13,7	47	48	42,09
8		106	43	11,15	47	48	42,56
9	106	43	5,89	47	48	47,97	
10	106	43	2,95	47	48	48,52	
11	106	43	0,96	47	48	42,73	
12	106	42	59,27	47	48	42,06	
13	106	42	50	47	48	42,06	

Таних тэмдэг

- лиценз
- эргэлтийн цэг

Гадаргын ус

- Булаг (2012 оны тооглоол)
- Гол
- Түр урсцагтай гол
- Нуур
- Байнгын
- Ширгадаг

Засаг захиргааны хил

- Аймгийн төв
- Сумын төв
- Сумын хил
- Аймгийн хил

Улсын ТХГН -ийн сүлжээ

- Тусгай хамгаалалттай газар
- Худгийн цооног
- НИТХТ-ын 50-р тогтоол

Хамгаалалтын бүсүүд

Засгийн газрын 194 болон 289-р тогтоол

- Голын хамгаалалтын бүсийн хил (Усны тухай хууль 22,3-т 200 метр)
- Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хил
- Голын хамгаалалтын бүс (Усны тухай хууль 22,1-т 50 метр)
- Ойн сан бүхий газар

МАСШТАБ 1:25 000

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэс

/АМГТГ-ын мэдээллийн сан 2019.01.30-ний байдлаарх талбай/

19-M017 дугаартай талбай нь

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.3, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.1-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, Ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дугаар тогтоолын Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай тус тус давхцалгүй байна.

Боловсруулсан: мэргэжилтэн Э.Эрдэнэхүү

Огноо: 19.03.22



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 19/М017

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн
Нийслэлийн Хан-Уул дүүргийн
12 дугаар хорооны нутаг дэвсгэр Сондуулт нэртэй
газарт орших 54.07 гектар талбайг хамарсан түгээмэл тархацтай ашигт малтмалын
ашиглалтын талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал
олборлохыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011137041 тоот гэрчилгээтэй
"Цээцээ Импекс" ХХК -д энэхүү тусгай зөвшөөрлийг 2034.02.12
дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН БОХИРДЛЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН



2019 оны 02 сарын 12 өдөр
Улаанбаатар хот



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

Тусгай
зөвшөөрлийн
дугаар 19/M017

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орх өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001	2019.02.12-нд олгосон, 2034.02.12-нд дуусах Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийн огноо: 2019.02.01	54.07	0	1	106°43'41.03"E	47°48'40.00"N
				2	106°43'39.70"E	47°48'50.87"N
				3	106°43'49.59"E	47°48'58.00"N
				4	106°44'11.02"E	47°48'58.00"N
				5	106°44'11.30"E	47°48'40.00"N
				1	106°42'50.00"E	47°48'40.00"N
				2	106°43'36.25"E	47°48'40.00"N
				3	106°43'32.78"E	47°48'49.15"N
				4	106°43'30.35"E	47°48'51.35"N
				5	106°43'22.44"E	47°48'52.19"N
				6	106°43'15.21"E	47°48'50.57"N
				7	106°43'13.70"E	47°48'42.09"N
				8	106°43'11.15"E	47°48'42.56"N
9	106°43'05.89"E	47°48'47.97"N				
10	106°43'02.95"E	47°48'48.52"N				
11	106°43'00.96"E	47°48'42.73"N				
12	106°42'59.27"E	47°48'42.06"N				
13	106°42'50.00"E	47°48'42.06"N				
				2019.02.12		Э.Баттулга
						

МОНГОЛ УЛСЫН ХУНД УНДВОРНИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ИЙН
ДУГНЭЛТ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар ХХ-07-05

Улаанбаатар хот

*Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших
"Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд"-д
2019 онд хийсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ,
тодотгол тооцооны үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай*

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд хийсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгээр геологич Д.Батсайхан, Г.Төрбат, Б.Буянхишиг нарын зохируулсан тайлан, уг тайлан дахь нөөцийн тооцоонд Монгол улсын зөвлөх геологич Г.Цэцэгэрэл, Монгол Улсын зөвлөх инженер, Барилгын материалын технологич инженер Д.Сүхбаатари нарны хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДУГНЭЛТ-ийг гаргав: Үүнд:

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших "Сондуулт" нэртэй 102.89 га талбайд бүхий 15/RO23 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг анх Нийслэлийн засаг захиргааны бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 15/04 дүгээр захирамжаар "Эрдэс плазм" ХХК-д олгосон байдаг бөгөөд Улаанбаатар хотын Байгаль орчны газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/65 тоот захираагчар Сондуулт нэртэй түгээмэл тархацтай ашигт малтмалын 15/RO23 тоот тусгай зөвшөөрлийг "Цэцээ Импекс" ХХК-д бүхэлд нь шилжүүлсэн байдаг.

Дээрх түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэн барилгын чулууны нөөцийг бүртгүүлж тус нөөц бүртгүүлсэн талбайд "Сондуулт" нэртэй 54.07 га талбай бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын 15/RO23 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Нийслэлийн засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/71 дүгээр захирамжын дагуу "Цэцээ Импекс" ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдөр олгосон байдаг.

Тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 10-р хороо, 10-р төвөөс баруун урагш 30 км-т номинклатурын L-48-10 хавтгайд оршино.

"Цэцээ Импекс" ХХК нь "Сондуулт" нэртэй түгээмэл тархацтай ашигт малтмалын 15/RO23 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 2019 онд гүйцээх хайгуулын ажлыг гүйцэтгэж геологийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр барилгын чулуу, геологи-хайгуулын ажилд нийт 126 915 800 төгрөг зарцуулсан байна.

3. 1960 онд геологич Н.В.Чернышев Улаанбаатар хот орчмын талбайд барилгын чулууны тоосгоны шаврын эрлийн ажил гүйцэтгэсэн бөгөөд 1990-1992 онд Т.Өнөдэлгэр,

Д.Банзрагчийн Улаанбаатар хот орчим талбайд 1:50000-ны масштабын гидрогеологи, геогрaфийн геофизик, геофизик, геохимийн судалгааны иж бүрдэл эрлийн ажил гүйцэтгэжээ.

“Цээцээ Импекс” ХХК нь 2017 онд “Сондуулт” талбайн баруун хэсэгт хайгуулын ажил гүйцэтгэн үр дүнгийн тайлан бичсэн бөгөөд “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” гэж нэрлэн 2017 онд нөөцийг В+С зэрэглэлээр 2382.57 мян.м³ буюу 6313.8 мян.тн гэж тооцоолсон ба нөөцийн тооцоо бүхий тайланг ЭБМЗ-ийн хуралд хэлэлцүүлэн 2018 оны 07 сарын 05 өдрийн ХХ-09-12 дугаар дүгнэлт, АМГТГ-ын даргын 2018 оны 09 сарын 25 өдрийн н/109 дугаар тушаалаар нөөцийг бүртгүүлсэн байдаг.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын 19/М017 тоот тусгай зөвшөөрлийн талбайд миссисип Алтан-Овоо формацийн /С_{1-2a0}/ алевролитлаг жижиг дунд ширхэгтэй, алевропсаммитлаг структуртай, цул текстуртай зүүн хойш 80°-ын суналтай, баруун хойш 340°-ын азимутаар 40-50°-ын уналтай граувак элсэн чулуу тархсан байхаас гадна голоцены үеийн (дрQ_{III-IV}) элс, хайрга, шавар, элсэнцэр, дайргын хэмхдэс зэрэг чулуулгууд тархсан байдаг.

4. “Цээцээ Импекс” ХХК нь 2017-2019 онд хээрийн хайгуул судалгааны ажлыг хээрийн хүчээр, 1:2000-ны масштабын байрзүйн зураглалын ажил болон цэг холболтын ажлыг “Од сүрвэй” ХХК, Баганат өрөмдлөгийн ажлыг “Легион дриллинг” зэрэг ХХК тус тус гүйцэтгэжээ.

Хайгуулын ажлын хүрээнд 150-200м х 350м-ийн торлолоор хайгуулын 5 шугамын дагуу 20-90 метрийн гүнтэй 12 цооног буюу 560.0 т/м баганат өрөмдлөгийн ажил хийж, ордоос нийт 100 дээж авсан бөгөөд БАК-ын лабораторид 88 ширхэг дээжийг физик-механикийн хураангуй шинжилгээнд, 12 ширхэг дээжийг физик-механикийн бүрэн шинжилгээ, бат бэх чанарын-2, элэгдэх чанарын шинжилгээ-5, химийн болон эрдсийн найрлага тодорхойлох шинжилгээнд тус тус 2 дээж, бетоны найрлага тодорхойлох шинжилгээнд (БАК-ын лаборатори-д) 1 дээж, МХЕГ-ын харъяа Үндэсний Аюулгүй Байдлын Лавлагаа Лаборатори (Цацрагын хяналтын шинжилгээ)-д 3 дээж, мөн 3 дээжинд петрографийн бүрэн бичиглэлийг Геологийн төв лабораторид тус тус шинжилгээнд хамруулсан байдаг.

5. Физик механикийн бүрэн шинжилгээний үр дүнгээр асгаасын нягт 1245 кг/м³, ширхэгийн дундаж нягт 2.65 г/см³, сүвэрхэг чанар 0.47 %, бутрамтгай чанар 5.2 %, бутлагдсан хэсэг 100 %, нимгэн үзүүрлэг хэсэг 5.2 %, тоос шавар шороон хэсгийн агуулга 0.2 %, бүхэл шавар байхгүй, ус шингээлт 0.45 %, органик хольц-шаардлага хангана, чийглэг 0.2 % зэрэг үзүүлэлттэй байна.

Мөн бат бэх шинж чанарын судалгаагаар (MNS 2998:2009, MNS 1272:99 стандартын дагуу) чийг 0.1%, эзлэхүүн жин 2.65 г/см³, сүвэрхэг чанар 0.38 %, ус шингээлт 0.40 %, шахалтын бат бэх дунджаар 104.65 МПа, хүйтэн тэсвэрлэлт дунджаар 1.42%, урвалжих чадвар нь дунджаар шүлтийн концентрацийн бууралт 133.67 ммоль/л болон уусдаг цахиур SiO₂-ын агууламж 22.4 ммоль/л, элэгдэх чанарын хувьд 5 дээжинд хийсэн судалгаагаар 13.7%-15.6% хооронд хэлбэлзэж, дунджаар 14.9 % байна.

Ордын барилгын чулууны химийн найрлага нь SiO₂-ын агуулга дунджаар 73.1%, Al₂O₃ дунджаар 11.75%, Fe₂O₃ дунджаар 2.5%, CaO дунджаар 4.48%, MgO дунджаар 0.55%, SO₃ дунджаар 0.86% байна.

Цэцраг идэвхжиллийн судалгаагаар ордын чулуулаг дахь радиин эквивалент нь 110.0-174.0 Бк/кг, дунджаар 144.7 Бк/кг байна.

“Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-д зохих лабораторийн шинжилгээ, туршилт хийлгэсний үр дүнг технологийн шаардлагатай харьцуулж үзсэнээр тус ордын барилгын чулууны түүхий эд нь зам, барилгын чулуу, дайргаар ашиглах боломжтой нь тогтоогдсон ба MNS 2803-2004 стандартын дагуу M400 болон түүнээс дээш маркийн бетон эдлэхүүн үйлдвэрлэж боломжтой гэж үзжээ.

6. Зохиогчид Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын геологийн нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 15736.05 мян.м³ (41.70 сая.тн)-ээр, боломжтой (C) зэрэглэлээр 3664.27 мян.м³ (9.71 сая.тн)-ээр, нийт бодитой болон боломжтой (B+C) нөөцийг 19400.32 мян.м³ (51.41 сая.тн)-ээр тооцоолжээ.

Шинжээч дээрх нөөцийн тооцоог хянаж, дахин тооцоод ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээж авахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж үзэв.

7. Ордыг ашиглах үеийн ундны усыг ойролцоох худгаас авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд ил аргаар олборлон орд ашиглах явцад үйлдвэрлэлийн хэрэгцээнд ус шаардагдахгүй гэж үзсэн.

8. Ордыг ашиглах техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр ордыг ил аргаар, тэвэртэй ашиглалтын системээр нийт 30 жилийн хугацаанд ашиглах бөгөөд жилд 543 мян.м³ дайрга олборлон, нийт 15.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатайгаас ордыг ашиглаж эхлэхэд 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх ба хөрөнгө оруулалтаа 4.1 жилд нөхнө гэж тооцоолжээ.

9. Цаашид техник-эдийн засгийн үнэлгээг боловсруулахдаа байгаль орчны үнэлгээнүүд, ТЭЗҮ-ийг эрх бүхий байгууллагаар үндэслэлтэй боловсруулах, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг төлөвлөгөөний дагуу хийх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ, АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг АМГТГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв.
Гүнд:

Нэг. “Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин Уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд хийсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайлан дахь (2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар) барилгын чулууны геологийн нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 15736.05 мян.м³ (41.70 сая.тн)-ээр, боломжтой (C) зэрэглэлээр 3664.27 мян.м³ (9.71 сая.тн)-ээр, нийт бодитой болон боломжтой (B+C) нөөцийг 19400.32 мян.м³ (51.41 сая.тн)-ээр энэхүү дүгнэлтийн хавсралт дахь хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан барилгын чулууны ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Гурав. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан ЭБМЗ-ийн 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ХХ-09-12 дугаар дүгнэлтээр ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн Морин уулын өмнөд хэсгийн дайрганы ордын түгээмэл тархацтай ашигт малтмалын 19/М017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой (В) зэрэглэлээр 940.18 мян.м³ (2.49 сая.тн), боломжтой (С) зэрэглэлээр 160.67 мян.м³ (0.425 сая.тн), нийт бодитой болон боломжтой (В+С) 1100.84 мян.м³ (2.917 сая.тн) барилгын чулууны нөөцийг тус тус хасч нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Дөрөв. Энэхүү дүгнэлтийн 9-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа эрэгжүүлж ажиллахыг "Цээцээ импекс" ХХК (Э.Гантуяа)-д анхааруулах.


Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Цээцээ импекс" ХХК (Э.Гантуяа)-д даалгах.

Зургаа. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин Уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайлангийн боловсруулалтын ажлыг "Цариг ресурс" ХХК, түүний геологич Д.Батсайхан, Г.Төрбат, Б.Буянхишиг, лабораторийн шинжилгээг Барилга архитектур корпорацийн лаборатори, Геологийн төв лаборатори, 1:2000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг "Од сурвэй" ХХК, тайлан, түүн дэх нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг шинжээч МУ-ын зөвлөх геологич С.Алтангэрэл, хайгуулын ажлын үнэн бодит байдал, бүх төрлийн дээжлэлтийг "Цээцээ импекс" ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:
ЭБМЗ-ИЙН ДАРГА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.МӨНХТӨР

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

Б.БАЯРСАЙХАН

**“Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ын нөөцийн тодотгол
 тооцооны нэгдсэн хүснэгт**

(Ордын нөөц 2019 оны 03 дугаар сарын 15-ны байдлаар)

/Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 19/М017/

Хүснэгт №1

№	Нөөцийн зэрэглэл, хэсэгшлийн дугаар	зузаан, м		Талбай, мян.м ²	Хөрсний эзэлхүүн, мян.м ³	Хэсэгшлийн эзэлхүүн, мян.м ³	Нөөц, мян.тн
		хөрс	чулуулаг				
1	В-1	2.3	29.3	29.56	68.69	867.43	2,298.68
2	В-2	2.1	35.7	10.67	22.89	380.91	1,009.41
3	В-3	2.3	42.3	94.68	221.15	4,004.11	10,610.89
4	В-4	2.2	48.2	37.20	82.77	1,792.52	4,750.19
5	В-5	2.3	44.7	114.37	268.45	5,113.93	13,551.91
6	В-6	2.2	45.2	79.23	170.58	3,577.15	9,479.44
7	С-1	2.5	19.1	4.01	9.83	76.72	203.31
8	С-2	1.3	35.1	1.73	2.23	60.51	160.34
9	С-3	1.4	36.1	1.73	2.36	62.45	165.48
10	С-4	2.7	21.6	12.92	34.29	279.41	740.43
11	С-5	2.4	48.5	6.80	16.00	329.59	873.41
12	С-6	2.5	20.2	0.96	2.44	19.42	51.46
13	С-7	2.2	59.4	2.33	5.19	138.16	366.13
14	С-8	2.3	37.1	26.43	62.08	981.18	2,600.12
15	С-9	2.3	42.3	8.68	20.17	367.16	972.98
16	С-10	2.2	29.7	25.59	55.82	759.84	2,013.58
17	С-11	2.1	40.7	7.44	15.59	302.49	801.60
18	С-12	2.2	24.9	11.56	25.22	287.35	761.49
Бодитой В нөөц				365.71	834.53	15,736.05	41,700.52
Боломжтой С нөөц				110.17	251.21	3,664.27	9,710.32
Нийт В+С нөөц				475.88	1,085.74	19,400.32	51,410.84



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 4/59.

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4.4.1 дүгээр хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн үйлдвэрлэлийн зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ХХ-07-05 дугаар хуралтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/M017 тоот ашиглалтын талбай зөвшөөрөлтэй Сондуулт нэртэй талбайн Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайлан дахь геологийн нөөцийг нийт бодитой болон боломжтой (С) зэрэглэлээр 19,400.32 мян.м³ буюу 51.41 сая.тн-оор хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тооллогоор бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн үйлдвэр Н.Мөнхбилэг/-д зөвшөөрсүгэй.

3. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны үйлдвэрлэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн үйлдвэрлэлтийн төв архивд хүлээлгэн өгөхийг "Цээцээ импекс" ХХК /Э.Гантуяа/-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 7/149

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн Т/20-09-04 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Баян сумын нутагт орших MV-020603 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Каймекс ХХК-ийн Баруун сайрын хөндийн дунд хэсэг, жалга-4 нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Төв аймгийн Баян сумын нутагт орших MV-020603 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун сайрын хөндийн дунд хэсэг, жалга-4 нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Каймекс ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

53701275



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар Т/94.

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн т/19-10-13 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/M017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цээцээ импекс ХХК-ийн Морин уул өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцугай.

2. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/M017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Морин уул өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгөхийг Цээцээ импекс ХХК-д даалгасугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 06 сарын 20 өдөр

Дугаар Т/19 - 10 - 13

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/М017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай

“Цээцээ импекс” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК-ийн боловсруулсан Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/М017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Д.Бадам шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн эдийн засгийн гол үзүүлэлтүүд, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн хэмжээсүүд, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Бутлан ангилах технологи, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Төслийн эдийн засаг зэрэг 10 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 141 хуудас тайлбар бичиг, 20 хавсралт зургаас бүрдэж байна.

2. 19/М017 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын ХХ-07-09 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн н/59 дүгээр тушаалаар ордын нөөц нь бодитой В зэргээр 15,736.05 мян.м³ дайрга, боломжтой (С) зэргээр 3,664.27 мян.м³ дайрга бөгөөд нийт (В+С) зэргээр 19,400.32 мян.м³ дайрганы нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо олборлолтын явцад бохирдол болон хаягдал үүсгэн олборлохоор тооцсон байна. Ашиглалтын үеийн хаягдал 1.52%-иар (520.5 мян.м³), бохирдол 0.6%-иар (83.6 мян.м³) тооцсон ба ордыг 30 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 1,856.8 мян.м³ хөрс хуулж, магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 14,021.6 мян.м³ дайрга

олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 525.0 мян.м³ дайрга бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 0.13 м³/м³.

4. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн шинж чанар, зэргийг харгалзан үзэж авто тээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

5. Тус уурхайд CAT-330 маркийн экскаватор – 1 ширхэг, 25 тн даацтай Howo маркийн автосамосвал -11 ширхэг хүртэл, Shantui SD-13 маркийн бульдозер - 1 ширхэг, Liugong 855H маркийн дугуйт ачигч - 1 ширхэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

6. Ордын туршилт судалгааны ажлыг “Барилга архитектур корпораци”-ийн бетон дүүргэгчийн лабораторид хийлгэсэн байна.

7. Туршилт шинжилгээний үр дүнгээр тус ордын дайрга нь хүнд бетон эзэлхүүний түүхий эд, барилгын зуурмаг, хуурай хольц мөн авто зам, нисэх, төмөр замын барилга байгууламж суурин болон хучилтын байгууламжийг барих дайрганы /MNS-0392-2014/ стандарт шаардлагыг хангаж байна.

8. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5916:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлын үр дүнд үүссэн ухашийг нөхөн тэгшлэх, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

9. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 2.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 262.5 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 1,275.6 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 225.5 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 181.5 сая төгрөг, хаалтын дараах хяналтын зардалд 58.4 сая төгрөг зарцуулахаар тусгажээ.

10. Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 11.7 тэрбум төгрөг ба ашиглалтын 30 жилийн хугацаанд 140.6 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, дайрганы нэгжийн өртөг 10,026 төг/м³ байхаар тооцжээ.

11. Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт 35.8 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх бөгөөд борлуулалтын үнийг ойролцоо орших ордын борлуулалтын үнээр, дайрганы фракц хамаарахгүй 14000 төг/м³-р тооцсон байна.

12. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, тоосжилтын асуудалд онцгой анхаарах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

13. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, ордыг ашиглах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

14. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам" – г тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь мөрдөж ажиллахыг анхааруулж байна.

15. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

16. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер Д.Бадам хариуцах.

17. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд ахин тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

18. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/М017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.МӨНХТӨР

**“Цээцээ импекс” ХХК-ийн Улаанбаатар хотын Хан-Уу
барилгын чулууны ордын үйлдв**

№	Нөөцийн зэрэг, блокийн дугаар	Геологийн нөөц				Ашиглалтын нөөц					
		Зузаан, м		Талбай, мян.м ²	Хөрсний эзэлхүүн, мян.м ³	Ашигт малтмал		Ашиглалтын блокийн талбай, мян.м ²	Хөрсний эзэлхүүн, мян.м ³	Ашигт малтмал	
		хөрс	чулуулаг			Нөөц, мян.м ³	Нөөц, мян.тн			Нөөц, мян.м ³	Нөөц, мян.тн
1	В-1	2.3	29.3	29.6	68.7	867.4	2,298.7	28.57	84.4	602.4	1,596.3
2	В-2	2.1	35.7	10.7	22.9	380.9	1,009.4	10.50	30.5	234.1	620.4
3	В-3	2.3	42.3	94.7	221.2	4,004.1	10,610.9	93.40	270.5	3,506.0	9,290.9
4	В-4	2.2	48.2	37.2	82.8	1,792.5	4,750.2	35.72	106.3	1,374.4	3,642.1
5	В-5	2.3	44.7	114.4	268.5	5,113.9	13,551.9	113.80	326.7	4,661.9	12,354.1
6	В-6	2.2	45.2	79.2	170.6	3,577.2	9,479.4	79.20	226.3	3,469.9	9,195.3
Бодитой В нөөц		2.2	40.9	365.7	834.5	15,736.1	41,700.5	361.19	1,044.7	13,848.7	36,699.1
7	С-1	2.5	19.1	4.0	9.8	76.7	203.3	0.38	11.5	1.0	2.6
8	С-2	1.3	35.1	1.7	2.2	60.5	160.3	1.30	4.9	3.1	8.1
9	С-3	1.4	36.1	1.7	2.4	62.5	165.5	1.60	4.9	9.6	25.5
10	С-4	2.7	21.6	12.9	34.3	279.4	740.4	5.06	36.9	38.5	101.9
11	С-5	2.4	48.5	6.8	16.0	329.6	873.4	4.93	19.4	28.6	75.7
12	С-6	2.5	20.2	1.0	2.4	19.4	51.5	2.75	2.7	15.4	40.9
13	С-7	2.2	59.4	2.3	5.2	138.2	366.1	1.02	6.7	6.4	17.0
14	С-8	2.3	37.1	26.4	62.1	981.2	2,600.1	7.20	75.5	91.7	242.9
15	С-9	2.3	42.3	8.7	20.2	367.2	973.0	8.09	24.8	134.8	357.3
16	С-10	2.2	29.7	25.6	55.8	759.8	2,013.6	5.32	63.1	80.7	213.7
17	С-11	2.1	40.7	7.4	15.6	302.5	801.6	5.70	21.3	92.5	245.0
18	С-12	2.2	24.9	11.6	25.2	287.4	761.5	8.65	43.0	107.6	285.2
Боломжит С нөөц		2.2	34.6	110.2	251.2	3,664.3	9,710.3	52.0	314.7	609.8	1,615.8
Нийт В+С нөөц				475.9	1,085.8	19,400.3	51,410.9	413.2	1,419.9	14,458.4	38,314.1

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглахад уурхайн хүрээ хязгаарт зайлшгүй үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын даг үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан В' зэргээр 14,021.6 мян.м³ буюу 37,157.1 мян.тн дайрга болж байна.



Уулын инженер: /А.Эрдэнэбулган /



л дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн
эрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

Хүснэгт № 1

Ашиглалтын үеийн хаягдал			Ашиглалтын үеийн бохирдол			Үйлдвэрлэлийн нөөц			
Хаягдал, 3.6%	Хаягдал нөөц, мян.м ³	Хаягдал нөөц, мян.тн	Бохирдол, 0.6%	Бохирдол, мян.м ³	Бохирдол, мян.тн	Магадласан үйлдвэрлэл- ийн нөөц	Хөрсний эээлхүүн, мян.м ³	Барилгын чулууны нөөц, мян.м ³	Нөөц, мян.тн
3.6%	21.7	57.5	0.6%	3.5	9.2				
3.6%	8.4	22.3	0.6%	1.4	3.6	В'	102.6	584.2	1,548.0
3.6%	126.2	334.5	0.6%	20.3	53.7	В'	37.6	227.0	601.6
3.6%	49.5	131.1	0.6%	7.9	21.1	В'	376.4	3,400.0	9,010.1
3.6%	167.8	444.7	0.6%	27.0	71.5	В'	147.8	1,332.8	3,532.0
3.6%	124.9	331.0	0.6%	20.1	53.2	В'	467.6	4,521.1	11,980.8
	498.6	1,321.2		80.1	212.3				
								13,430.2	35,590.1
3.6%	0.0	0.1	0.6%	0.0	0.0	В'			
3.6%	0.1	0.3	0.6%	0.0	0.0	В'	11.5	0.9	2.5
3.6%	0.3	0.9	0.6%	0.1	0.1	В'	5.0	3.0	7.9
3.6%	1.4	3.7	0.6%	0.2	0.6	В'	5.2	9.3	24.8
3.6%	1.0	2.7	0.6%	0.2	0.4	В'	38.1	37.3	98.8
3.6%	0.6	1.5	0.6%	0.1	0.2	В'	20.3	27.7	73.4
3.6%	0.2	0.6	0.6%	0.0	0.1	В'	3.2	15.0	39.7
3.6%	3.3	8.7	0.6%	0.5	1.4	В'	6.8	6.2	16.5
3.6%	4.9	12.9	0.6%	0.8	2.1	В'	78.3	88.9	235.5
3.6%	2.9	7.7	0.6%	0.5	1.2	В'	28.9	130.8	346.5
3.6%	3.3	8.8	0.6%	0.5	1.4	В'	65.6	78.2	207.3
3.6%	3.9	10.3	0.6%	0.6	1.6	В'	24.0	89.7	237.6
							46.2	104.4	276.5
	22.0	58.2		3.5	9.3				
							343.6	591.3	1,567.0
	520.5	1,379.3		83.6	221.6	Нийт В'	1,856.8	14,021.6	37,157.1

ртөж буй боломжтой С зэргийн нөөцийг оруулан хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай
у бодитой (В), боломжтой (С) зэргийн нөөцийг магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын



ЦЭЭЦЭЭ-ИМПЕКС ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2019.01.04 № 13/104

танай _____-ны № _____-г

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулж ирүүлсэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 15/R23 дугаартай тусгай зөвшөөрөлтэй дайргын ордыг ашиглах төсөлд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаас заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2019 оны 3 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

А.ЭНХБАТ



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

2019 оны 01-р сарын 04

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2019/Т-004

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Цээцээ-импекс” ХХК, регистрийн дугаар-2804816, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 18 дугаар хороо, Бэлхийн гудамж, 54-314.

Төслийн нэр: Дайрганы орд ашиглах

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 15/R23 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбайд хэрэгжинэ.

Холбоо барих утас: 976-91913170

Орон нутгийн санал: Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 05/586 тоот саналыг харгалзав.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт			Тийм	
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	

Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Хөрсөн бүрхэвч			
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм
	Ургамлан нөмрөг			
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм
	Амьтны аймаг			
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм
	Нутгийн оршин суугчид			
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм
Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	
Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
Түүх, соёлын биет өв				
Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм	
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	

Нэгдсэн дүгнэлт:

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 15/R23 дугаартай тусгай зөвшөөрөлтэй дайрганы ордыг ашиглах төсөлд хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.

Онцгойлон анхаарах зүйлс:

1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолт, боловсруулалтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;
2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /ургамал, хөрс, ус, амьтан, агаар/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг урьдчилан тооцож, нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;
3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан нарийвчлан судалж, төсөл хэрэгжүүлэгчийн сонгосон аргаар байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүйгээр тухайн ордыг ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дүгнэлт өгөх;
4. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;
5. Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцох;
6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх;
7. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;
8. Төсөл хэрэгжихээс өмнө тухай уурхайн эдэлбэр газарт Газрын төлөв байдлын чанарын хянан

баталгааг хийлгэж, цаашид 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байхыг тайланд тусгах;
9. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар болон БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг авч тайланд хавсаргах;
10. Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хаягдлыг хэрхэн зайлуулах, түүнээс байгаль орчин учирч болох сөрөг нөлөөллийг нарийвчлан тооцож тайланд тусгах;
11. Төсөлд ашиглах усны хэмжээг батлагдсан аргачлалын дагуу тооцоолох, усны нөөцийн эх үүсвэр хүрэлцээтэй эсэх талаар холбогдох байгууллага, нэгжээс дүгнэлт гаргуулах;
12. Төсөлд ашиглах авто замын трассыг тогтоох, авто тээврийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцоолох, бууруулах зөвлөмж боловсруулж тайланд тусгах;
13. Төслөөс "Морин уул" локатор, цаг уурын станц болон нисэх онгоцны буудлын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар тухайн байгууллагаас нь санал авч дүгнэлт гарган нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах, саналыг тайланд хавсаргах;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

Ерөнхий үнэлгээ хийсэн:
**Байгаль орчин, аялал жуулчлалын
яамны шинжээч**



1117138217
УХА0579 9085084

Д.ТЭМҮҮЛИН

Ерөнхий үнэлгээний үр дүнг
зөвшөөрсөн:
"Цэцээ-импекс" ХХК-ийн захирал

Э.ГАНТУЯА



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА**

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр,
Утас: 7000-3714, Факс: (976) 7000-3714
E-mail: TuulRBA@gmail.com

2023.10.11 № 04/570
танай 2023.09.28 -ны № 59 -Т

ЦЭЭЦЭЭ ИМПЕКС ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.ГАНТУЯА
ТАНАА

Монгол Улсын Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, танай компанийн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 59 дугаар албан бичгийн дагуу "Барилгын чулууг олборлож, бутлан ангилах үйлдвэр"-ийн 2022 оны хаягдал усны дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.


Хаягдал усны дүгнэлтээр тавигдсан шаардлагыг хангаж ажиллана уу.

Хувийг: Хан-Уул дүүргийн Засаг дарга, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэст.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НЯМДОРЖ



ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
"ЦЭЭЦЭЭ ИМПЕКС" ХХК-ИЙН
ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2023 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар ХУД 23/130

Улаанбаатар хот
Утас: 91915431, 89055431

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг:

"Цээцээ импекс" ХХК, Захирал Э.Гантулга, Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт, их булгийн ам, 9191-5431, 89055431, УБД - 901137041, РД - 2804816

2. Төслийн нэр, байршил:

- "Цээцээ импекс" ХХК-ийн "Морин уулын өмнөд хэсэг"-ийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төсөл. Хан-уул дүүрэг, 12-р хороо, Сондуулт нэртэй газарт байрладаг, 47°48'52.62"N, 106°43'25.47"E

3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:

- Хэрэглээнээс гарсан бохир усыг бетон доторлогоотой цооногт хуримтлуулж, "Бар сүүлт" ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан гэрээний дагуу автоцистернээр зөөвөрлөн хотын бохир усны шугамын өмнөд коллекторт нийлүүлдэг.

4. Цэвэрлэгээний арга, түвшин:

- Хаягдал бохир усыг дахин цэвэршүүлэн ашигладаггүй.

5. Хаягдал усны хэмжээ:

- Унд, ахуйн хаягдал усны хэмжээ: 46 хүн x 150 л/хүн x 208 хон = 1'435.2 м³

6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:

- Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Барилга хот байгуулалтын Сайдын 2019 оны А-816/218 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-гээр тооцов. Бохирдуулах бодисын төрөл: Ажилчдын тосгон - 1.5 кг/м³.

7. Ус бохирдуулсны төлбөр, тооцоо:

Хаягдал усны хэмжээ (м ³)	Жишиг хэмжээ (кг/м ³)	Бохирдуулах бодис (кг)	Ус бохирдуулсны төлбөр (төг/кг)	Нийт төлбөр, төг
1,435.2 м ³	1.5	2,152.8	50.0	107'640.0

- Ус бохирдуулсны төлбөр: 107'640.0 /Нэг зуун долоон мянга зургаан зуун дөчин/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.10, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

8. Хууль тогтоомж, дүрэм журам, норм стандартын талаар талаар зөвлөмж:

- "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаас давсан бохирдолтой хаягдал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах;



- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг Хан-уул дүүргийн Засаг даргаар сунгуулах;

- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам" -ын 2.1.4, 3.6.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:

- - Өмнөх оны хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд жилд нэг удаа хаягдал усны сорьц авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд хүргүүлэх;

- Хаягдлын сангийн нэвчилт, шүүрэлтийг хянах зорилгоор мониторингийн цооног байгуулж тогтмол хяналт тавьж ажиллах;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүнгүүд, хаягдал усны төлбөр төлсөн баримтыг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

ХЯНАСАН:
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ ДАРГА




П.ЭНХБАЯР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН



Н.ЦОГТ



Шилжүүлгийн баримт/Transaction receipt

From: noreply@khanbank.com

To: tsetsee_impex2014@yahoo.com

Date: Monday, October 30, 2023 at 06:21 PM PDT

Огноо/Date: 2023.10.31 09:21:09

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 3812191

Системийн огноо/System Date: 2023.10.31 09:21:09

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5176306088	ЦЭЭЦЭЭ-ИМПЕКС	181,462.50 MNT	1.00
/ Нэг зуун наян нэгэн мянга дөрвөн зуун жаран хоёр төгрөг Тавин мөнгө /				
Кт/To	Банкны дугаар/Branch No - IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Банкны нэр/Bank Name Khan Bank - Хаан банк Нэр/Name МТА.ТАТВАР	181,462.50 MNT	1.00
	5176120446			

Гүйлгээний утга/Transaction description:
1231000237172; 2804816; 91915431

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

Сурталчилгаа/Advertisement:



ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 08 сарын 28 өдөр

№

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, 6356354 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 2804816 тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах, АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ - "ЦЭЭЦЭЭ ИМПЕКС" ХХК чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг /цаашид Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2023 оны 08-р сарын 28-ны өдрөөс 2024 оны 08 сарын 28-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.
- 1.6 Хороо нь гэрээний дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж Захиалагч, Гүйцэтгэгч хороондын уялдааг хангана.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх, ачилтын мэдээг тухай бүр хороонд мэдээлж ажиллах үүрэгтэй.
- 2.2 Гүйцэтгэгчийн тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар зохион байгуулалт хийн хогийг ачуулах арга хэмжээг авна.

- 2.3 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ААНБ-аас гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн нэмэлтээр барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
- 2.6 Хорооноос өгсөн чиг үүргийн дагуу Гүйцэтгэгч нь тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй ААНБ-ын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал "Хог хаягдлын тухай" хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 ААН, байгууллага нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх.
- 3.3 Тээвэрлүүлэх хог хаягдлыг зөвхөн тогтоосон хог ачилтын цэг буюу бункерт хийх, ачилт хийхэд саадгүй байхаар орц, гарцыг төлөвлөсөн байна.
- 3.4 ААН, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4.12, 10 дугаар зүйлийн 2.10 дах заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон, "хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
- 3.5 Захиалагч тал нь гэрээний 3.2, 3.3-т заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.6 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25-нд Хан-Уул дүүргийн Татварын Хэлтэст болон itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэн төлнө.
- 3.7 Хогийн сав, бункерийн орчимд машин, болон бусад зүйл байрлуулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.8 Захиалга буюу хог хаягдал ачих, тээвэрлэх дуудлагыг 2-3 хоногийн өмнө хороо болон гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 3.9 Хог хаягдал тээвэрлүүлсэний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.10 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.11 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.12 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.13 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.14 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1 Гэрээт хугацаанд захиалгаар иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу захиалгаар 85000 төгрөг байна.

- 4.3 Захиалэгч нь E-tax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө.
- 4.4 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.
- 4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.
- 4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикайн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.6-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.3 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.
- 6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.3 Тус гэрээнд дүүрэг, хорооноос тогтоосон "хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын зураглалыг хавсаргасан тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

Найм. Нэмэлт өөрчлөлт

20..... оны сарын-ны өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Ажлын дахь өдөр ачилт хийх.

Ес. Гэрээний сунгалт

- 9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 2023 оны 08 сарын 28 өдрөөс 2024 оны 08 сарын 28 өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: _____
Гэрээ сунгасан: _____
Тайлбар: _____

9.1.2 Энэхүү гэрээг 20... оны ... сарын ... өдрөөс 20.. оны ... сарын ... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: _____
Гэрээ сунгасан: _____
Тайлбар: _____

Арав. Гэрээ байгуулсан талууд

Гүйцэтгэгч тал:
ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв
ОНӨААТҮГ-ын хороо хариуцсан хяналтын
ахлах мэргэжилтэн
албан тушаалтай

.....
/ Р.Алтанцэцэг /
Утас:80805479
Хаяг:



Захиалагч тал:
"Цэвэр-Импекс" ХХК-н захирал
/ Э.Гантуяа /
Утас: 89055431
Хаяг: ХУД, 12-р хороо,



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000006108938003231018000003041356
Борлуулагчийн:
ТТД: 6108938
НЭР: Хот тохижилтын газар
Хаяг: Монгол, Улаанбаатар, Чингэлтэй, 12-р хороо, , Булаг 18
тоот
Утас: 11453501

Огноо: 2023-10-18
Худалдан авагчийн:
ТТД: 2804816
Нэр: Цээцээ-Импекс
Хаяг: Монгол, Улаанбаатар, Сүхбаатар, 18-р хороо, 54, 314
